ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/159/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2019 он


Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч: Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг:
Аудитор: Б.Отгон-Өлзий
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ
3

2 Аудитын тайлан
5

2.1 Оршил ..... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 7

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 7

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....

2.11. Шилэн дансны мэдээлэл .....

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....

3 Менежментийн захидал

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/141

танай______________-ны №______________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЛБА-ӨӨШ ДОЛООД САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Б.ЯЛАЛТБАЯР ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Галба-Өөш Долоодын сав газрын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Галба-Өөш Долоодын сав газрын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Галба-Өөш Долоодын сав газрын захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Ялалтбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 08-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ний аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь тухайн сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Си ти эс” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 41 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,347.98 мянган төгрөгөөс тооцон *5,347.98* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 208,305.8 мянган төгрөгөөр буюу 28.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 8,231.0 | 1,424.5 | (6,806.5) |
| Үндсэн хөрөнгө | 631,106.8 | 534,366.4 | (96,740.4) |
| **Нийт хөрөнгө** | 639,337.8 | 535,790.9 | (103,547.0) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 639,337.8 | 535,790.9 | (103,547.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 744,096.7 | 535,790.9 | (208,305.8) |

Бараа материал дансанд 989.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1,795.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1,236.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 6,672.3 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авч, нийт 17,527.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас 6,806.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгөнд хуримтлагдсан элэгдэл тооцсоноос 96,740.4 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалан эзний өмч 103,547.0 мянган төгрөгөөр тус тус хорогдсон байна.

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргааны тайлант онд улсын төсвөөс 161,715.4 мянган төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 160,839.6 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Улсын төсвөөс санхүүжих | 161,715.40 | 160,839.64 | (875.76) | 99.5 |
| **Нийт дүн** | 161,715.40 | 160,839.64 | (875.76) | 99.5 |

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 161,715.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 160,839.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Урсгал зардлыг нийт 875.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цалин хөлс нэмэгдэл урамшууллыг 130.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийг 538.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 179.3 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 6.9 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 5.9 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 0.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласнаас шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 1,428.5 мянган төгрөгийн, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 508.0 мянган төгрөгийн нийт 1,936.5 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 850.0 мянган төгрөгийг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 578.5 мянган төгрөгийг, урсгал засварын зардал 508.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Аудитаар гүйцэтгэсэн горим сорилын үр дүнд алдаа зөрчил илрээгүй болно.

**2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

**2.13. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Галба-Өөш, Долоодын сав газрын захиргаа 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

# 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 3.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,231,033.31** | **1,424,500.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8,231,033.31 | 1,424,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 8,231,033.31 | 1,424,500.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 57,000.00 | 328,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,534,033.31 | 696,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 640,000.00 | 400,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **631,106,800.84** | **534,366,354.47** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 631,106,800.84 | 534,366,354.47 |
| **392** | **Биет хөрөнгө** | 627,815,300.84 | 531,074,854.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 247,734,480.40 | 247,734,480.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (45,219,670.43) | (57,606,394.43) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 109,594,854.80 | 109,594,854.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (89,571,061.57) | (107,836,870.69) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 713,015,314.87 | 703,994,935.21 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (330,489,065.82) | (382,700,195.74) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51,329,286.24 | 50,127,401.49 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (28,578,837.65) | (32,233,356.57) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,291,500.00 | 3,291,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,291,500.00 | 3,291,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **639,337,834.15** | **535,790,854.47** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **639,337,834.15** | **639,337,834.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 639,337,834.15 | 639,337,834.15 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,291,500.00 | 3,291,500.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,291,500.00 | 3,291,500.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 636,046,334.15 | 532,499,354.47 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 636,046,334.15 | 636,046,334.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (103,546,979.68) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **639,337,834.15** | **535,790,854.47** |

## 3.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **852,371,586.95** | **163,851,886.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **693,703,386.95** | **200,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 693,703,386.95 | 200,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 693,703,386.95 | 200,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 200,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 693,703,386.95 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **158,668,200.00** | **163,651,886.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 153,188,200.00 | 161,715,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 153,188,200.00 | 161,715,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,480,000.00 | 1,936,486.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 508,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан | - | 1,428,486.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 980,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **218,953,006.68** | **267,398,865.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **218,953,006.68** | **267,398,865.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 209,132,334.68 | 266,323,100.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,179,513.00 | 116,669,261.00 |
| 210101 | Үндсэн цалин | 74,617,400.00 | 80,881,161.00 |
| 210102 | Нэмэгдэл | 15,813,113.00 | 23,983,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,749,000.00 | 11,804,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 12,559,035.00 | 14,520,664.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,406,289.00 | 8,979,160.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,050,785.00 | 2,061,036.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 827,190.00 | 928,125.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 206,798.00 | 259,723.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,067,973.00 | 2,292,620.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,400,000.00 | 11,400,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 11,400,000.00 | 11,400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,750,597.00 | 16,939,709.31 |
| 210401 | Бичиг хэрэг | 840,450.00 | 707,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,481,400.00 | 6,912,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,839,567.00 | 2,125,410.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 315,250.00 | 641,086.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 273,930.00 | 6,553,163.31 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,078,343.00 | 3,138,890.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 777,997.00 | 1,438,990.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,300,346.00 | 1,699,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,880,100.00 | 5,392,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,880,100.00 | 5,392,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 372,000.00 | 1,521,730.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 595,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 97,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 250,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 132,000.00 | 316,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60,912,746.68 | 96,740,446.37 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 60,912,746.68 | 96,740,446.37 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,820,672.00 | 1,075,765.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,820,672.00 | 1,075,765.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,820,672.00 | 1,075,765.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **633,418,580.27** | **(103,546,979.68)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **633,418,580.27** | **(103,546,979.68)** |

## 3.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **158,668,200.00** | **163,851,886.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **200,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 200,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 200,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 200,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **158,668,200.00** | **163,651,886.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 153,188,200.00 | 161,715,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 153,188,200.00 | 161,715,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,480,000.00 | 1,936,486.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 508,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,428,486.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 980,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **158,668,200.00** | **163,851,886.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **158,668,200.00** | **163,851,886.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **148,847,528.00** | **162,776,121.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 102,179,513.00 | 115,958,379.00 |
| 210101 | Үндсэн цалин | 74,617,400.00 | 80,170,279.00 |
| 210102 | Нэмэгдэл | 15,813,113.00 | 23,983,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,749,000.00 | 11,804,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 12,559,035.00 | 15,231,546.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8,406,289.00 | 10,514,122.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,050,785.00 | 1,236,956.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 827,190.00 | 928,125.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 206,798.00 | 259,723.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,067,973.00 | 2,292,620.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,400,000.00 | 11,400,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 11,400,000.00 | 11,400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,313,947.00 | 10,752,966.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 618,450.00 | 989,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,522,400.00 | 6,672,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,843,967.00 | 2,175,410.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 155,200.00 | 737,886.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 173,930.00 | 178,120.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,147,333.00 | 2,519,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,817,987.00 | 819,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,329,346.00 | 1,699,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,875,700.00 | 5,392,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,875,700.00 | 5,392,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 372,000.00 | 1,521,730.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 595,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 97,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 250,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 132,000.00 | 316,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,820,672.00** | **1,075,765.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,820,672.00 | 1,075,765.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,820,672.00 | 1,075,765.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

### 3.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,291,500.00 | - | 636,046,334.15 | 639,337,834.15 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,291,500.00** | **-** | **636,046,334.15** | 639,337,834.15 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,291,500.00** | **-** | **636,046,334.15** | 639,337,834.15 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,291,500.00** | **-** | **636,046,334.15** | 639,337,834.15 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (103,546,979.68) | (103,546,979.68) |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,291,500.00** | **-** | **532,499,354.47** | 535,790,854.47 |

### 3.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 161,715,400.00 | 160,839,635.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 161,715,400.00 | 160,839,635.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 161,715,400.00 | 160,839,635.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 116,088,400.00 | 115,958,379.00 |
| 210101 | Үндсэн цалин | 80,300,300.00 | 80,170,279.00 |
| 210102 | Нэмэгдэл | 23,983,300.00 | 23,983,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,804,800.00 | 11,804,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,770,300.00 | 15,231,546.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,744,400.00 | 10,514,122.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,267,000.00 | 1,236,956.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,001,600.00 | 928,125.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 419,400.00 | 259,723.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,337,900.00 | 2,292,620.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,579,300.00 | 11,400,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 107,400.00 | - |
| 210304 | Байрны түрээс | 11,471,900.00 | 11,400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,331,400.00 | 9,324,480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 990,000.00 | 989,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,827,200.00 | 5,822,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,175,600.00 | 2,175,410.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 160,400.00 | 159,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 178,200.00 | 178,120.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,017,000.00 | 2,011,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 820,000.00 | 819,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,197,000.00 | 1,191,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,393,000.00 | 5,392,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,393,000.00 | 5,392,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,536,000.00 | 1,521,730.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 600,000.00 | 595,830.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 97,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 27,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 250,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 319,000.00 | 316,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 160,839,635.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 160,839,635.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 160,839,635.00 |

## 3.6. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /НЭМЭЛТ ДАНС/ /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,936,486.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,936,486.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,936,486.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 1,428,486.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 850,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 578,486.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 508,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 508,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 1,936,486.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 1,936,486.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 508,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,428,486.00 |